

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

3-13

1. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

3-13

**Монгол Улсын Их Хурлын
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг /-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Болормаа;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Б.Батбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар;

Тасалсан: Н.Алтаниагай, О.Амгаланбаатар, Д.Ганбат, Б.Жаргалан, Н.Номтойбаяр, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Б.Энхбаяр.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Пунцагбалжир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, төслийн зөвшилцөх асуудлын талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, С.Эрдэнэболд, П.Наранбаяр нарын тавьсан

асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн тухай Байнгын хороодын хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 17 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
17 цаг 24 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Хажсекберийн Жангабыл гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд нар хүрэлцэн ирснээр Байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал нэг байгаа. Даргын дэргэдэх зөвлөлөөс Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газраас яаралтай горимоор өргөн баригдсан нэг асуудлыг хэлэлцэх асуудлыг оруулж өгсөн. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг, Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл байгаа, зөвшилцөх. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцье.

Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Эрчим хүчний яам Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Эрчим хүчний сайд, Нансалын Тавинбэх Эрчим мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганбаатарын Энхтүвшин Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батмөнхийн Пунцагбалжир Эрчим хүчний яамны ахлах шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр орж байгаа юм байна.

Ингээд Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна. Номер 5, 6 юм байна тээ? 6 номер.

Б.Чойжилсүрэн: Эрхэм Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлийн дагуу дулааны гуравдугаар цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг цахилгаанаар 300мвт-аар, дулаанаар 395 мвт-аар үе шаттай өргөтгөн шинэчлэх төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар

хооронд байгуулах “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг боловсруулан 2024 оны 4 дүгээр сард Оросын Холбооны Улсын эрчим хүчний сайдад хүргүүлсэн.

Оросын Холбооны Улсын Эрчим хүчний яамнаас уг хэлэлцээрийн төсөлд Оросын Холбооны Улсын Засгийн газар холбогдох яамдын саналыг авч, хариу тусган хариу саналыг 2024 оны 7 дугаар сард ирүүлсэн.

Тус хэлэлцээрийн төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй асуудлаар хоёр улсын Эрчим хүчний яам хооронд 2024 оны 8 дугаар сард харилцан зөвшилцөж ажиллалаа.

Мөн Оросын Эрчим хүчний сайдын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ю.Сорокинаас 24 оны 8 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн 13/232/М/Д тоот албан бичигт 2024 оны 9 дүгээр сард зохион байгуулагдах Монгол Улс, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нарын уулзалтын үеэр энэхүү хэлэлцээрийн төсөлд гарын үсэг зурах арга хэмжээг зохион байгуулах саналаа ирүүлсэн.

Хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн тохиолдолд Олон улсын гэрээний тухай хуулийн хүрээнд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой урьдчилан зөвшилцөх бөгөөд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн Ерөнхий сайдын захирамжаар хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Эрчим хүчний сайдад олгож, улмаар хэлэлцээрийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж соёрхон батлуулна.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь нийт 11 зүйлтэй бөгөөд тус хэлэлцээрт Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50мвт-ын блок станцаар өргөтгөх, дунд даралтын хэсгийн 48мвт-ын блок станцыг

буулгаж, суурин дээр нь 250мвт-ын блок станц шинээр барих төслийн зураг, төсөл боловсруулах инженерийн судалгаа, шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар ДЦС-3 ТӨК, гүйцэтгэгчээр Оросын талаас эрх олгосон “Интер РАО Экспорт” компанийг томилох асуудлыг тус тус зохицуулахаар тусгалаа.

Зураг төслийн ажлын үр дүнд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн барилга угсралтын ажлын нийт төсөвт өртөг, хугацааг нарийвчлан тодорхойлж, цаашид Оросын Холбооны Улсын Засгийн газрын экспортын зээлийн нөхцөл, барилга угсралтын ажил гүйцэтгэх зэрэг асуудлыг Оросын талтай хэлэлцэн тохиролцох нөхцөлийг бүрдүүлэх үндсэн баримт бичиг болох юм.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Олон улсын гэрээний тухай хуулийн хүрээнд хэлэлцээрийн төсөл, зарим Засгийн газрын тэмдэглэлийн төсөл болон Ерөнхий сайдын захирамжийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн танилцуулж байна.

Засгийн газрын гишүүдээс нийт 25 санал ирснээс 5 саналыг хүлээн авч, 20 саналыг тайлбарласан болно.

“Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн зураг, төсөл боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн даргад баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Мандхай танилцуулна. Мандхай гишүүний микрофоныг өгье.

М.Мандхай: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3-д заасныг баримтлан дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчийн зүгээс Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50мвт-ын блок станцаар өргөтгөх, дунд даралтын хэсгийн 48мвт-ын блок станцыг буулгаж, суурин дээр нь 250мвт-ын блок станц шинээр барих төслийн зураг, төсөл боловсруулах, инженерийн судалгаа, шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар ДЦС-3 ТӨХК, гүйцэтгэгчээр Оросын Холбооны Улсын талаас санал болгосон “Интер РАО Экспорт” компанийг томилох асуудлыг зохицуулахаар дурдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Жавхлан, Батсүмбэрэл, Уянгахушиг, Мандухай, Энхцэцэг, Энхтүвшин, Цэнгүүн, Лодойсамбуу нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар

хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж.

Г.Тэмүүлэн: Мандухай гишүүнд баярлалаа.

Та бүхэнд Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг бас уншаад танилцуулчихъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу дээрх хэлэлцээрийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Батболд, Түвшин, Даваасүрэн нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлт Аюулгүй байдал, гадаад бодлогын

байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Ингээд Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийн зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэсэн ийм санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооноос ирүүлсэн байна.

Ингээд хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Эрдэнэболд гишүүнээр, Наранбаяр гишүүнээр тасаллаа. Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд ийм хуралдаанаас I цагийн өмнө л тараах материал тараагаад л ингээд хэлэлцдэг ийм жишиг өмнөх парламент байсан юм, уу байхгүй байсан юм уу мэдэхгүй байна. Тэгэхдээ ингээд л I цагийн өмнө материал тараагаад л тэгээд л гялс яаралтайгаар хэлэлцээд ингээд л оруулж ирдэг л болчихоод байгаа юм байна л даа.

Уг нь энэ чинь яаралтай горим гэдэг дээр чинь арай өөр нөхцөлүүдээр л асуудлууд яаралтай хэлэлцдэг болмоор байх юм.

Хоёр асуулт байна. Энэ тараасан байгаа энэ гэрээг хоёр талаасаа хэлэлцсэн гэж ойлгож байгаа зөв үү? Хэрвээ хоёр талаасаа хэлэлцсэн бол энэ чинь гэрээ биш тулган шаардах бичиг байна шүү дээ. Монгол Улсын хууль тогтоомжид заасан худалдан авах ажиллагаа явуулахгүйгээр Монголын талын эрх олгогдсон байгууллага, Оросын талын эрх олгосон байгууллагатай зураг, төслийн гэрээг

байгуулна. Зураг, төсөлтэй боловсруулалттай холбоотой бүх баримт бичгийг бэлтгэхэд Орос, Монгол болон Англи хэлийг ашиглах ба Орос хэлийг давуу хэл болгон баталгаажуулна. Энэ зураг, төсөлтэй холбоотой Оросын Холбооны Улсын норм, дүрэм, стандартын дагуу зураг, төсөл боловсруулсныг баталгаажуулна гээд.

Тэгээд хэрвээ энэ хоёр талаасаа ажилласан гэрээ манай талаас өгсөн санал юм бол тэгээд ажлын хэсэгт ажилласан хүмүүс ийм тулган шаардаж байгаа юмыг хүлээн зөвшөөрөөд байгаа юм уу? Тэгээд ийм Монгол Улсад байгуулагдах гэрээн дээр Оросын Холбооны Улсын хэлийг давуу тал болгон баталгаажуулна, Оросын Холбооны Улсын норм, стандартыг батална. Монгол Улсын хууль тогтоомжид худалдан авах ажиллагаа Монгол Улсын хуулиар заасан худалдан авах, явуулах, худалдан авах үйл ажиллагаа явуулахгүйгээр Монголын талын эрх олгосон байгууллагатай гэрээ байгуулна энэ тэр гээд. Эд нар чинь жоохон гэрээ биш, зүгээр тулган шаардах бичиг өгчихсөн байна шүү дээ.

Тэгээд энэ дээр манай яг ажлын хэсгийнхэн манай сайд, Эрчим хүчний яам ямар байр суурь илэрхийлэх юм тэрийг нь сонсмоор байна. Ер нь мэдээж бид нар дулааны, цахилгааныхаа эрчим дутагдлыг нэмж нөхөх ийм зайлиггүй шаардлага байгаа шүү дээ. Хэдүүлээ энийг чинь сая Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр баахан л ярьцаасан. Тэгээд энэ гурван асуултад хариулт өгөөч.

Нэгдүгээрх нь тэр Монгол Улсын хууль тогтоомжид заасан худалдан авах ажиллагаа явуулахгүйгээр энэхүү гэрээг байгуулна. Гэрээ байгуулахтай холбоотой бүх баримт бичгийг Орос, Монгол болон Англи дээр ашиглах ба Орос хэлийг давуу тал болгоно. Оросын Холбооны Улсын норм, дүрэм, стандартыг баталгаажуулна гэсэн энэ дээр хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүний асуултад Чойжилсүрэн сайд хариулъя. 6 номер.

Б.Чойжилсүрэн: Шижир гишүүний асуултад хариулъя. Шижир гишүүнээ энэ өнгөрсөн гурав дахь өдөр Засгийн газар өргөн барих Их Хуралд хүргүүлнэ гээд бичгээр ирүүлээд, ирэх өнгөрсөн гурав дахь өдөр сүлжээнд тавьсан байгаа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд энийг хүргүүлсэн байгаа 2 хоногийн өмнө. Сүлжээнд байгаа. Би бүр Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандоржид хэлээд гишүүд ийм шүүмжлэл гарч магадгүй гээд эртхэн тавиадах гээд тавиулсан. Энийг Тамгын газрынхан тодруулчихъя тэгэх үү нэг.

Энэ таны хэлж байгаа гэрээ биш тулган шаардах бичиг байна гээд ийм юу зүйлүүд бий. Тухайлбал, энэ Орос хэлийг давуу байдал болгоно гээд. Ийм нөхцөлд гэрээ байгуулъя гээд ярьж байгаа. Энэ олон улсын гэрээ байгуулагдах учраас Монголын тендерийн хууль үйлчлэхгүй бас. “Интер РАО” компанийг бид нар энэ тендер монголдоо тендер зарлачихъя. Та нар ингээд орчих гэхээр бид нар тэгж тендерт орохгүй, бид нар тендерт орсон бичиг баримтаар дараа нь Оросын экспортын зээлийг бүтээж чадахгүй гэдэг ийм зүйл ярьсан.

Норм, стандартын тухайд бол манай Монгол Улсад бас бидний байгаа царай нь сүүлийн 30 жил ийм хүчин чадалтай станц ашиглалтад ороогүй учраас манай стандартууд хуучирсан байгаа учраас Оросын Холбооны Улсын стандарт цахилгааны талдаа манай салбар дээр Оросын стандарт, Монгол стандарт хоёр бараг цэг, таслалгүй давхцаж байгаа учраас Орос талаас Оросын стандартыг авчихъя гээд хэлчихсэн юм.

Гэхдээ Монголын тусгай шаардлагуудыг бол заавал тусгана шүү гэдэг ийм ойлголттой байгаа.

Г.Тэмүүлэн: Сая энэ тараасан материалтай холбоотой бас тодруулга хийгээдэхье. 28-ны өдөр буюу 3 дахь өдрийн үдээс хойш 4, 5 цагийн үед Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан байх.

Тамгын газраас гишүүдэд шуудангаар нь бас тараасан. Манай Байнгын хороо буюу бусад Байнгын хороодууд 28-ны өдрийнхөө 19 цагт бүгд Байнгын хорооныхоо группүүдээр бол цахимаар мэдээллүүд бас тавьсан байгаад байгаа. Тэгэхээр одоогоос 2 хоногийн өмнө тавьсан. Яаралтай горимоор ерөнхийдөө энэ ээлжит бус чуулганы дараа бол хэлэлцэгдэх нь гэсэн ерөнхий тэр тов байсан байгаа.

Шижир гишүүн болсон уу? Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Тамгын газар бол албан ёсоор вайбер /viber/ чатаар явуулсан зүйлээ энэ албан ёсны юм уу гэж асуухад албан бус гэж хариулж байсан шүү. Тэр гишүүдийн сургалт, тэр Их тэнгэрт болсон сургалт тэр. Тэгэхээр энийг бол албан ёсоор хүлээж авсанд тооцохгүй.

Би сая яг 1 цаг 20 минутын өмнө хүлээж авсан. Тэгэхээр ийм хариуцлагагүй байж болохгүй л дээ Улсын Их Хурлын Тамгын газар нэг.

Гурван асуулт байна. Яагаад яаралтай горимоор энийг оруулж ирж байгаа юм бэ? Ер нь уржигдар өгсөн байлаа ч гэсэн энэ чинь тухайн өдрийн ажлын цаг дуусчихсан байхад, тэгээд бид нарт 1 бүтэн өдөр яг энэ ээлжит бус чуулган хуралдаж байгаа ачаалал өндөртэй үед унишж танилцах ямар ч боломж олдохгүй нөхцөл байдалд яаралтай горимоор яагаад оруулж байгаа гэдгээ тайлбарлахгүй юу? Энийг

надад гэхээсээ илүүтэйгээр протоколд тэмдэглүүлмээр байна.

Хоёрдугаар асуулт яг энэ Чойжилсүрэн сайдаа та энэ яг эдийн засгийн үр өгөөж талаас нь энэ дээр тайлбар хийхгүй юү.

Жишээлбэл, энэ чинь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явж байгаа зүйл дээр энэнээс хамаагүй бага зардлаар болж бүтэх зүйл дээр шахалтад ороод ийм өндөр үнийн дүнтэй зүйл хийх гээд байна гэдэг хардалтууд яваад байгаа учраас нэгэнт энэ бид нар Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороогоор энэ асуудлыг ярьж байгаа учраас аюулгүй байдалтай холбоотой асуулт гурав дахь асуулт нь.

Ер нь энэ Монгол Улсын энэ аюулгүй байдлын шалгуурыг энэ яаж хангаж байгаа юм бэ? Сая та хариулахдаа жишээлбэл, Монголын талын онцгой нөхцөлүүдийг тусгахаар ярилцсан байгаа гэдэг зүйл хэлчих юм. Тэр нь тэгвэл яг Монголын талын тусгай нөхцөлүүд нь яг ямар ямар нөхцөлүүдийг яаж яаж тусгахаар та болон энэ ажлын хэсэг төлөвлөж байгаа юм бэ гэсэн энэ гурав дахь асуулт нь шүү.

Ер нь бол байна шүү дээ энэ бид нар ингээд тусгаар улсын Хууль тогтоох байгууллагын Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороогоор энэ асуудлыг хэлэлцэж байгаа шүү гэдгээ эрхэм гишүүд ухамсарлаасай гэж бодож байна.

Цаашидаа ямар ямар асуудлууд дээр ийм яаралтай горимоор ийм илтэд Монгол Улсын Их Хурлыг үл хүндэтгэсэн, Их Хурлын үйл явц, парламент ёсыг үл хүндэтгэсэн ажлууд орж ирэх вэ гэдгийг мэдэхгүй байна. Тэгээд энэ асуултад хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя. 6 номер.

Б.Чойжилсүрэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Ер нь сайт

дээр бол 28-ны өдөр 19 цагт тавьсан нь үнэн. Бас иймэрхүү хардлага гомдол гарах болов уу гэж бодоод Их Хурлын Тамгын газрынханд би гуйсан. Энийг эртхэн тавьж өгөөч гээд. Тэр бусад асуудлыг бол яг албан ёсных гэдгийг бол яг үнэндээ би Их Хурлын харилцааг тайлбарлаж мэдэхгүй байна. Тайлбарлах нь ч утгагүй байх гэж бодож байна.

Эдийн засгийн үр өгөөж талаасаа гээд ингэхлээр 1 тэрбум 326 сая еврогоор барина гэсэн ийм саналууд Оросууд хэлдэг. Бид нар ийм өндөр үнэтэй юмаар чинь чадахгүй ээ, бариулж чадахгүй ээ, үнээ буулга гэдэг, үнэ буулгая гээд ингэхлээр зураг, төсвөө хийж байж бид нар үнэ эцсийн нь тохирно гэдэг Оросуудын хэлэлцээрийн дүнд л бид нар энийг зураг, төсвийг нь л хийх гэж байгаа одоо. Зураг, төсөв хийсний дараа үнэ, цар хэмжээ бүгд тодорхой болно. Бид нар бол 814 орчим сая доллароор байвал энэ хэлэлцээрийг цааш нь хэрэгжүүлэх бололцоотой, цааш нь хөгжүүлэх бололцоотой. Ийм тэрбум 326 сая еврогоор авахгүй гэдгээ олон дахин илэрхийлсэн.

Зээлийн нөхцөл Оросын Холбооны Улсын Засгийн газрын экспортын зээл авах гэж байгаа хөнгөлөлттэй нөхцөлтэй ийм зээл. Энэ зээлийн хүүг багасгая, хугацааг уртасгая гэдэг ийм саналыг Сангийн сайдаас ч явуулсан, Эдийн засгийн хөгжлийн сайдаас ч явуулсан, би ч бас Оросын Холбооны Улсад очиж ажиллахдаа биечлэн энийг тайлбарлаж байгаа. Манай Өрийн удирдлагын тухай хуулийг заавал дагаж мөрдөнө, хөнгөлөлтийн түвшин бол 30-аа доошоо орох ёсгүй шүү гэдэг ийм зүйл ярьж байгаа юм.

Ямар нөхцөл вэ гээд ингэхлээр одоо энэ цахилгаан станц барихад бол магадгүй 4, 5 мянган стандартууд хэрэг болно. Дагаж мөрдөх. Манай стандарт, Оросын Холбооны Улсын стандарт хоёр зөрсөн тохиолдолд манай тусгай шаардлагын стандартыг барина шүү

гэдэг зүйлийг энэ гэрээний төсөл дээр суулгасан.

Гэхдээ манайд яг ийм цахилгаан станц барих хэмжээний бүрэн стандарт, туршлага сүүлийн 34 жилд харамсалтай нь алга байна. Ийм учраас ингээд энэ Оросын талын энэ харилцан буулт хийгээд л ийм юм болчихсон.

Үнэ буулгахын тулд бид нар энэ зураг, төсвийг хийх гэж байгаа юм. Зураг, төсөв хийгээд эхлэхийн тулд хамгийн эхний ээлжид бол инженер, геологийн судалгаа хийнэ. Азаар аятайхан хөрс гарах юм бол үнэ буух байх. Үнэ шинжилгээний дүнгээр төвөгтэй гарч ирэх юм бол хөрсний нэмэлт ажлууд хийгдэнэ, төслийн өртөг ч нэмэгдэнэ, зураг, төсвийн өртөг ч нэмэгдэх ийм л байдалтай байгаа юм.

Яагаад яаралтайгаар оруулсан юм бэ гээд ингэсэн энэ ирэх 9 дүгээр сарын 3-ны өдөр, ирэх долоо хоногийн хоёр дахь өдөр Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путин Монгол Улсад ажлын айлчлал хийх юм байна. Энэ айлчлалын үеэр хоёр улсын харилцааг бодоод энэ гэрээнд гарын үсэг зуръя. Зураг, төсөл боловсруулах нь шүү зөвхөн.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэр гурав дахь асуудал болохоор тэр аюулгүй байдлын шалгуур гэдэг улс орны тусгаар тогтнолтой холбоотой энэ асуудал байна шүү дээ. Тэгэхээр аюулгүй байдлын шалгуур гэдэг дээр та салбар хариуцсан сайдын хувьд ямар байр суурьтай байгааг чинь бас би протоколд үлдээмээр байна.

Дахиад нэг зүйлийг хэлэхэд бол аль нэгэн улсын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлах болгонд тэрэнд зориулсан нөхцөл байдлаар бид нар ингээд Их Хурлынхаа процессыг зөрчөөд ингэж явах нь зөв юм

уу, буруу юм уу? Энэ дээр та ямар байр суурьтай байна?

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд 6 номер.

Б.Чойжилсүрэн: Аюулгүй байдлын ямар шалгуур байдаг гэдэг яг тэр стандартыг нь би бол харамсалтай нь мэдэхгүй байна. Танд Энхбаяр сайд та нэмж хариулаач. Би бол энэ дээр хариулж чадахгүй юм байна. Хууль, дүрэм зөрчөөгүй. Одоо энэ гурван намын Засгийн газар байгуулаад “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэдэг ийм нэртэй Засгийн газар байгуулагдсан. Хурдтай ажиллах шаардлага байна. Гишүүд ч тэр, Засгийн газар ч тэр ард түмэндээ бид нар олон зүйл амласан. Энэ ажлынхаа бүгдийг чаддаггүй юм гэхэд дийлэнхийг нь хийчихмээр байна гэж бодоод л энэ асуудлыг оруулж ирсэн. Оросын Холбооны Улсын д талаасаа бас хоёр Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр энийг зурчихъя гэдэг ийм хүсэлт илэрхийлсэн учраас энийг нь хүлээж аваад л болж байгаа юм. 48 цагийн өмнө материал тараагдсан гэж ойлгож болох байх.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуултад нэмж ажлын хэсгээс нэмж хариулах уу? Энхбаяр сайд хариулах уу? Энхбаяр сайд нэмж тайлбар, мэдээлэл өгье Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Миний бие энэ Улсын Их Хурлын сонгуулийн өмнө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гэж Үндсэн хуулийн дараа орох томоохон эрх зүйн бичиг баримт, тулгуур бичиг баримт байгаа. Тэн дотор үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүд гэж бий. Түүн дотор онцгой байр суурь нь эрчим хүчний аюулгүй байдал гэж асуудал байгаа. Эрчим хүчний аюулгүй байдал Монгол Улсад ноцтой алдагдаж байгаа, улс орны эдийн засгийн хөгжил, хүн амын өсөн нэмэгдэж байгаа энэ хэрэглээг хангахад эрчим хүчний

өнөөгийн байдал хүрэлцээгүй. Доголдож байгааг бүгд мэдэж байгаа. Иймд эрчим хүчний салбарыг яаралтай либералчлах.

Хоёрдугаарт, манай эрчим хүчний систем үндсэндээ хуучнаар Зөвлөлт Холбоот Улсын үед хөрөнгө оруулалт, техник технологи, турбин генератор бүгд тэн дээр тэдний зураг, төсөл дээр тооцогдож баригдсан, ашиглалтад орсон.

Тэгэхээр тэр станцыг өргөтгөх асуудал ярьж байгаа болохоор энэ нь өөрөө Оросын Холбооны Улсын тэр үйлдвэрлэл, тоног төхөөрөмжтэй холбож өргөтгөх нь зүйтэй.

Хоёрдугаарт, зээлийн нөхцөл.../минут дуусав./

Г.Тэмүүлэн: 1 минут нэмээд өгье.

Ж.Энхбаяр: Нөгөө талаас тайлан өгсөн зээлийн таатай нөхцөл байгаа. Дэлхийн зах зээлийн эх үүсвэр 10 хувиас доош орохгүй байгаа үед 2 хувийн 20 жилийн хугацаатай үндсэн төлбөрөөс 5 жил чөлөөлөгдөж байгаа энэ бол Монгол Улсад ялангуяа дутагдаж байгаа эрчим хүчний хэрэглээг хангахад энэ ТЭЦ-3-ыг өргөтгөхөд онцгой ач холбогдолтой гэж үзэж энийг Оросын Холбооны Улстай хийх нь зүйтэй гэдэг ийм бодлого байгаа.

Нөгөө талаас эрчим хүчний салбар буюу бүх салбар дахь хоёр хөршийн хөрөнгө оруулалтыг, балансыг тэнцвэржүүлэх нь улс орны аюулгүй байдлын гол эрх ашиг байдаг. Харамсалтай нь энэ салбар дахь хөрөнгө оруулалтын байдал тэнцвэр алдагдсан. Энэ тэнцвэртэй байдлыг хангахад Оросын Холбооны Улсын санхүүжилтээр хийгдэх энэ ТЭЦ-3-ын өргөтгөл онцгой чухал ач холбогдолтой гэдэг асуудал Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр яригдаж тухайн үед бодлогын чиглэл гарч байсан гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Тэгэхээрээ улс орны аюулгүй байдал, эрчим хүчний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын олон зүйл, заалтад нийцтэй анх удаа ярьж байгаа юм биш, олон жил ярьж байгаа. Харин энэ Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн ажлын хүрээнд багтаж энэ гарын үсэг зурах, зураг, төсөл боловсруулах ажлыг эхлэх нь зүйтэй байгаа юм.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэгвэл хаалттай болгочхож болно шүү дээ. Тийм ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Чойжилсүрэн сайдын нөхцөл байдлыг аягүй сайн ойлголоо л гэж бодлоо. Зүгээр та бол хэлж байна шүү дээ Тэр 814 сая доллароор бол боломжтой гээд олон удаа тавьсан. 1.3 тэрбум гаран еврогийн асуудал яригдаж байна гээд байгаа тийм үү? Тэгэхээр нэгэнтээ ингээд нөгөө яаралтай горимоор ороод ирж байна гэж байгаа боловчиг уг нь боломжийн хувьд гэх юм бол заавал айлчлалд түргэн түүхий шахагдахгүйгээр нэгэнтээ энийгээ олон нийтийг мэдээлэлжүүлээд, тооцоо судалгаагаар маш сайн гаргаад явбал зөв байна гэдэг би тийм байр суурийг бол энэ протоколд тэмдэглүүлье гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Наранбаяр гишүүн асуулт асууя.

П.Наранбаяр: Эрчим хүчийг өнөөдрийн дутагдалтай байдлыг арилгахад хийж байгаа томоохон алхам гэдгийг хүлээн зөвшөөрнө.

Гэхдээ ингээд энэ хэлэлцээрийн төслийг харахаар бас яах вэ та бүхэн маань жоохон анхаарвал зүгээр юм уу гэсэн ганц, хоёр юм харагдаад байгаа юм. Тэр түрүүнд хэлний асуудал байна. Давамгайлах хэлний асуудал. Энэ норм,

дүрэм, стандартуудыг Оросын Холбооны Улсын норм, дүрэм, стандартуудыг баримталж, төсөл боловсруулна, баталгаажуулна гэхихсэн заалт нь. Цаашаагаа ер нь бүхий л засвар үйлчилгээ чинь тэднийхээр л явчихна гэсэн үг.

Тэгэхээр уг нь түрүүнд би бас Чойжилсүрэн сайдын энэ ингээд хариултыг сонсож байхад манайх ийм зураг, төсөл хийсэн ийм туршлага байхгүй гээд ярьж байна. Гэтэл Бөөрөлжүүтийг хийчихсэн шүү дээ. Бөөрөлжүүт чинь бас л энэнтэй харьцуулахад хамаагүй хямдаар тусаж байна. Тэгээд танилцуулгыг харахаар Оросын талтай хүүгээ яриад тохироогүй л юм байна л даа тийм ээ? Тэгээд Оросууд ийм та нарт хүүгийн хөнгөлөлт үзүүлж чадахгүй ээ, манай эдийн засгийн нөхцөл байдал хэцүү байна гэсэн тайлбартай л байгаа юм байна. Энэ цаашдаа хүүг нь бууруулах тал дээр бас бодолцоно биз. 1.5 бараг хүүтэйгээ нийлээд евро байна шүү дээ. Тоглоом бас биш.

Тэгэхээр энэ дээр бас та бүхэн маань бодоод үзээрэй. Тэгээд бас хамгийн гол нь зураг, төсөл боловсруулах эрх олгогдсон байгууллага гээд шууд энэ “Интер РАО” хэлэлцээр рүүгээ оруулаад ирчихсэн ийм нөхцөл байгаад байгаа нь бас жоохон эргэлзэхэд хүргээд л байна л даа.

Тэгэхээр энэ мэдээж аливаа зүйл тийм ямар шар цавуугаар наасан биш аливаа юм чинь өөрчлөгддөг, хэлэлцээний явцад өөрчлөгддөг. Тэгэхээрээ нэлээн дипломат хэлэлцээгээ чанаржуулах, хүчжүүлж, өөрийн талын захиалагчийн талын бас өөрийн гэсэн хүчтэй байр суурь гэж хэлэх юм уу ийм бас зээлийг нь төлөх нь манай тал өөрсдөө шүү дээ. Тэгэхээр энэ дээр ч гэсэндээ өөрсдийнхөө бас байр суурийг нөгөө талдаа ойлгуулж, дипломат тандалт хийх энэ юмнуудаа бас их сайн хийх ёстой юм болов уу даа гэж бодож байна. Зүгээр энэ эрчим хүчний энэ салбарт үнэхээрийн энэ ДЦС,

тэр дотроо нүүрснийх тийм айхтар миний бодлоор шүү дээ айхтар тийм өнөөдрийн хамгийн сүүлийн үеийн технологи ашиглаж байгаа ч юм бас биш шүү дээ. Манайд бол яг энэ чиглэлээр бариад зураг, төслийг нь хийчихээр ийм компаниуд ч гэсэн байгаа шүү дээ. Ерөөсөө Сэргэлэн суманд энэ Бөөрөлжүүтийг барьж л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тал дээр та бүхэн ямар бодолтой байдаг юм? Зүгээр асуулт байна.

Г.Тэмүүлэн: Наранбаяр сайдын асуултад Чойжилсүрэн сайд хариулъя. 6 номер.

Б.Чойжилсүрэн: Наранбаяр сайдын асуултад хариулъя. Наранбаяр сайдаа манайх жижиг улсын зовлон байна. Эрчим хүчний бүрэн хараат бус болно гэдэг бол манайх шиг жижиг улсад төвөгтэй. Энэ цахилгаан станцын тоног төхөөрөмжүүдийг бид нар дотооддоо өөрсдөө үйлдвэрлэдэг болсон цагт энэ хараат бус байдлаас гарна. Тэгсэн тохиолдолд тодорхой хэмжээнд бид нар Оросын станцыг Оросын тоног төхөөрөмжөөр, Хятадын үйлдвэрлэснийг Хятадаас, бусад улсынхаа, гуравдагч улсыг бол гуравдагч улсын тоног төхөөрөмжийг худалдаж аваад тэд нараас тодорхой хэмжээнд хараат байх нь үнэн.

Хоёрдугаарт, нүүрсний төслийн тухайд бол дэлхий дээрх аягүй төвөгтэй болчихлоо шүү дээ. 2015 онд Парисын хэлэлцээр байгуулагдсанаас хойш барууны бүх улс орнууд нүүрсний төслийг санхүүжүүлэхгүй байгаа. Бас тоног, төхөөрөмжийг нь үйлдвэрлэж нийлүүлэхгүй байгаа. Хамгийн сүүлд 2021 онд Хятад Улсын дарга Ши Жиньпин дарга НҮБ-ын 177 дугаар чуулган дээр байх Хятад Улс Хятадын газар нутгаас гадна цахилгаан станцыг санхүүжүүлэхгүй гэдэг ийм улс төрийн амлалт авчихсан. Энэ нь тэр Хятадын бүх төрийн байгууллагуудын шийдвэр болчихсон.

Ер нь товчхондоо дүгнээд хэлэх юм бол одоогоос 2015 оноос өмнөх нөхцөл байдалтай одоо бид нар энэ санхүүжилт босгох боломж маань бараг 90 хувь хаалттай болчихсон байгаа ийм л нөхцөл. Энэ Оросын Холбооны Улс бол энэ Парисын хэлэлцээрт нэгдэн ороогүй цөөхөн улсын нэг нь энэ.

Тийм учраас энэ Оросын Холбооны Улсыг хөнгөлөлттэй эх үүсвэрээр станцыг бариулъя гэдэг шийдвэрийг 2019 онд гаргасан юм байна лээ. Түүнээс хойш л энэ хэлэлцээрийн дүнд яваад байгаа юм. Нэгэнт тэр бүх улс орнуудын экспортын зээл хөнгөлөлттэй, татаастай зээл өгч байгаа бол өөрийнхөө орны технологи, өөрийнхөө орны тоног төхөөрөмжийг нийлүүлнэ гэдэг нь бүх улсуудын, ганц Оросын Холбооны Улс биш бүх улс орнууд ийм л бодлого баримталдаг энэ дагуу явж байгаа.

Харин зуухных нь тухайд бол энэ ТЭЗҮ дээрээ бол Хятадын орчин үеийн Дон фанк ч юм уу, Шанхайн Электрик ч юм уу энэ хоёроос зуухыг нь бол Хятадаас нийлүүлье гэдэг ийм ТЭЗҮ-ийг боловсруулаад ирүүлчихсэн байгаа.

Бид нарт бол их тийм айхтар сонголт байхгүй байна. Биднийг гуйгаад байгаа юм байхгүй. Бид харин энийгээ энэ төслийг хэрэгжүүлчхээч. Жилдээ бид нар 260 орчим мегаваттаар манай цахилгаан эрчим хүчний чинь хэрэглээ өсөж байна шүү дээ. ТЭЦ-3 өөрөө 171 мвт-ын сүлжээ нийлүүлж байгаа. 198 мвт-ын суурилагдсан хүчин чадалтай, дотоод хэрэглээтэйгээ хасахлаар 171 гэсэн үг.

ТЭЦ-3 дээр нэмэх нь дахиад 100 мвт-ын блокийг жил болгон ашиглалтад оруулж байж бид нар өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хүчнийхээ хэрэглээг хангах ийм бодит хүндрэлийг хангах ийм бодит хүндрэл дунд тулчихсан байгаа.

Г.Тэмүүлэн: *Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.*

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Сая асуулт асуусан гишүүдтэй холбогдуулаад би хоёр, гуравхан пойнтыг бас протоколд тусгуулаад хэлчихье гэж бодоод байгаа юм. Тэгээд Чойжилсүрэн сайд бас анхаарна биз. Энэ бол нэгдүгээрт гол зарчмын асуудал нөгөө гишүүдийн бас эргэлзэж байгаа, тээнэгэлзэж байгаа зүйл бол нэгдүгээрт энэ бол зөвхөн зүгээр төслийн зураг, төсөл боловсруулах Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл байгаад байгаа юм. Нэгдүгээрх нь.

Тэгэхээр энэ бол нэгдүгээрт төслийнхөө техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсвийг бол та бүхэн маань хийх нь байна. Ингээд тодорхой хугацаа шаардагдана.

Ингээд энэний дараагаас бол та бүхэн маань нөгөө талтайгаа яг гишүүдийн асуугаад байгаа сая үнэ өртөг болоод эдийн засгийн үр өгөөжтэй холбоотой асуудлууд дээр бол дахиад хэлэлцээгээ үргэлжлүүлээд, олон улсын стандартад нийцүүлэх, зардлыг нь юу гэдэг юм эдийн засгийн үр өгөөжийг нь яг тооцоолж, эдийн засгийн тооцоо судалгаагаараа нотолж гаргаж ирж байж дараа нь Улсын Их Хуралд орж ирж соёрхон батлах хэлэлцээр бол 2 дахь удаагаа явна гэсэн үг.

Тэгэхээр бол мэдээж техник эдийн засгийн үндэслэл хийх асуудал бол тодорхой хугацаа шаардагдана. Тодорхой хэмжээний зардал бол мэдээж гарна. Ингээд эргээд буцаад тэрний дараа та бүхэн хэлэлцээ хийгээд Улсын Их Хурал руу орж ирэх ийм процедурын асуудал ууд байгаа шүү л гэдэг асуудлууд байгаа.

Тэгэхээр мэдээж бид нар энэ эрчим хүчний өргөтгөл хийх асуудал дээр дургүйцэж байгаа, энийг эсэргүүцэж

байгаа юм бол байхгүй. Гол асуудал нь саяын тэр эдийн засгийн үр өгөөж, тооцоо судалгаатай холбоотой асуудал. Энийг та бүхэн маань ТЭЗҮ-гээ хийж дуусгасны дараа, тодорхой хугацааны дараа эргээгээд үр дүнг нь бид нарт танилцуулаад соёрхон батлуулах төслөө бол оруулж ирэх юм байна гэж ойлгож байгаа шүү.

Чойжилсүрэн сайд бол толгой дохиж байна. Ингээд ийм нөхцөлтэйгөөр бол бид нар энэ зөвхөн төслийн зураг, төсөл боловсруулах энэ хэлэлцээрийг бол бас зөвшилцөх эсэх асуудлыг бол явуулах гэж байна гэж ойлгож байна.

Ингээд санал хураалтыг явуулж эхэлье.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулах юм байна. Ингээд энэ томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Нийт санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн дэмжиж, 84.6 хувиар дэмжигдсэн байна.

Ингээд энэ асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

17.56 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР